## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/2015 оны жилийн эцсийн байдлаар/

<table>
<tr><th>№</th><th>Зорилт</th><th>Арга хэмжээ</th><th>Хэрэгжилт</th><th>Яам, агентлагийн үнэлгээ</th><th>ЗГХЭГ-ын үнэлгээ</th><th>Тайлбар</th></tr>
<tr><td colspan="7">НЭГ.АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН</td></tr>
<tr><td>1</td><td>115.Хөшигийн хөндийд шинээр барих олон улсын нисэх онгоцны буудлыг олон улсын зорчигч болон ачаа тээврийн өрсөлдөх чадвар бүхий төв болгох</td><td>115.7.“Цахим гадаад паспорт”-ыг нэвтрүүлнэ.<br><br>Хэрэгжүүлэх байгууллага: ГХЯ, МТШХХГ<br><br>Хугацаа: 2013-2015 он</td><td>
<table>
<tr><th rowspan="2">Хугацаа</th><th colspan="2">Төсөв</th><th rowspan="2">Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</th></tr>
<tr><th>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ</th><th>Төсвийн гүйцэтгэл</th></tr>
<tr><td>2012 он</td><td>-</td><td>-</td><td rowspan="2">Цахим гадаад паспортын судалгааны ажил хийж, танилцуулга бэлтгэсэн.</td></tr>
<tr><td>2013 он</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>2014 он</td><td>-</td><td>-</td><td>Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай төсвийн судалгааг хийж, 2015 оны төсөвт тусгуулах саналыг Хууль зүйн яаманд хүргүүлсэн боловч батлагдаагүй.</td></tr>
<tr><td>2015 он</td><td>-</td><td>-</td><td>-Гадаад хэргийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн А/64 дүгээр тушаалаар “Монгол Улсын үндэсний цахим гадаад паспортын загвар”-ыг баталсан.<br>-Тус газраас “Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Хууль зүйн яаманд хүргүүлсэн.<br>-Засгийн газрын 2015 оны 402 дугаар тогтоолоор цахим гадаад паспортын бэлдэц худалдан авах гэрээ байгуулах эрхийг тус газрын даргад олгосон.<br>-Бүгд Найрамдах Унгар Улсын “Hungarian Banknote Printing Shareholding Corporation” компанийн холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт, танилцуулга хийж, гэрээний төслийг боловсруулан, санал солилцон ажиллаж байна.<br>-Цахим гадаад паспортын бэлдэцийг</td></tr>
</table>
</td><td>80%</td><td></td><td></td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><td></td><td></td><td></td><td>худалдан авах болон хэвлэх үйлдвэрийн гэрээний төслийг боловсруулан Хууль зүйн яам, Тагнуулын ерөнхий газарт хүргүүлсэн.<br>-Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай төсвийн судалгааг хийж, 2016 оны төсөвт тусгуулах саналыг Хууль зүйн яаманд хүргүүлсэн болович батлагдаагүй.</td></tr>
<tr><td>Нийт дүн</td><td>-</td><td>-</td><td></td></tr>
<tr><td>Үр дүн, үр нөлөө</td><td colspan="3">Цахим гадаад паспорт хэрэглээнд нэвтрээгүй байгаа тул ямар нэгэн үр дүн, үр нөлөө гараагүй байна.</td></tr>
<tr><td>Тайлбар</td><td colspan="3">Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгө шийдвэрлэгдээгүйн улмаас энэхүү арга хэмжээ хэрэгжээгүй.</td></tr>
</table>
<table>
<tr><td colspan="2">2016 оны</td></tr>
<tr><td>Улсын төсөвт туссан дүн</td><td>Хүлээгдэж буй гүйцэтгэл</td></tr>
<tr><td>-</td><td>-“Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг шинэчилсэн найруулгаар Засгийн газраас батлах;<br>-Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн асуудлыг шийдвэрлэх;<br>-Цахим гадаад паспортын бэлдэцийг нийлүүлэх, паспорт хэвлэх компанитай гэрээ байгуулж, цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх.</td></tr>
</table>
</td>
<td></td>
<td></td>
<td></td>
</tr>
<tr>
<td>2</td>
<td>175.Иргэдийг цахим карт, хувийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн сантай болгож, эрүүл мэндийн даатгалтай иргэн харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх</td>
<td>175.1.Иргэдэд эрүүл мэндийн даатгалын ухаалаг цахим үнэмлэх олгоно.<br><br>Хэрэгжүүлэх байгууллага: ХАХНХЯ, МТШХХГ, УБЕГ<br><br>Хугацаа: 2013-2015 он</td>
<td>
<table>
<tr><td rowspan="2">Хугацаа</td><td colspan="2">Төсөв</td><td rowspan="2">Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</td></tr>
<tr><td>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ</td><td>Төсвийн гүйцэтгэл</td></tr>
<tr><td>2012 он</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>2013 он</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>2014 он</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>2015 он</td><td>-</td><td>-</td><td>-Эрүүл мэнд, спортын яаманд байгуулагдсан “Ажлын хэсэг”-т тус газрын нэг албан тушаалтан ажиллаж байна.<br>-“Ажлын хэсэг”-ийн хүрээнд эрүүл мэндийн</td></tr>
</table>
</td>
<td>20%</td>
<td></td>
<td></td>
</tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td></td><td>
<table>
<tr><td></td><td></td><td></td><td>даатгалын цахим карт ашиглах журмын төсөлтэй танилцаж, санал хүргүүлсэн.</td></tr>
<tr><td>Нийт дүн</td><td>-</td><td>-</td><td></td></tr>
<tr><td>Үр дүн, үр нөлөө</td><td colspan="3">Эрүүл мэндийн даатгалын ухаалаг цахим үнэмлэх хэрэглээнд нэвтрээгүй байгаа тул ямар нэгэн үр дүн, үр нөлөө гараагүй байна.</td></tr>
<tr><td>Тайлбар</td><td colspan="3">Энэхүү арга хэмжээ нь төсөв санхүү болон хэрэгжүүлэгч бусад байгууллагаас шалтгаалан хэрэгжээгүй байна.</td></tr>
</table>
<table>
<tr><th colspan="2">2016 оны</th></tr>
<tr><th>Улсын төсөвт туссан дүн</th><th>Хүлээгдэж буй гүйцэтгэл</th></tr>
<tr><td>-</td><td>-Эрүүл мэнд, спортын яамнаас тендер зохион байгуулах;<br>-Эрүүл мэндийн даатгалын ухаалаг цахим үнэмлэхийг хэрэглээнд навтрүүлэх.</td></tr>
</table>
</td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>3</td><td></td><td>175.2.Эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох техникийн болон бусад бэлтгэл ажлыг хангаж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.<br><br>Хэрэгжүүлэх байгууллага: ЭМЯ, МТШХХГ, УБЕГ<br><br>Хугацаа: 2013-2015 он</td><td>
<table>
<tr><th rowspan="2">Хугацаа</th><th colspan="2">Төсөв</th><th rowspan="2">Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</th></tr>
<tr><th>Улсын төсвийн хөрөн ө оруулалтын хэмжээ</th><th>Төсвийн гүйцэтгэл</th></tr>
<tr><td>2012 он</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>2013 он</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>2014 он</td><td>-</td><td>-</td><td>-Эрүүл мэнд, спортын яам, Үндэсний статистикийн хорootой хамтран ажиллаж, хүн амын мэдээллийн санг улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулгалт хийж, зөрүүг арилгах арга хэмжээ авсан.</td></tr>
<tr><td>2015 он</td><td>-</td><td>-</td><td>-Төрөлт, нас баралтын тооны зөрүүг багасгах, мэдээллийн сангийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэнд, спортын яамтай хамтран ажиллах “Эх болон нялхсын эндэгдлийн бүртгэл” нэртэй төсөл боловсруулсан ба энэ төслийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдэж байгаа төрөлт, нас баралтын мэдээллийг цахим байдлаар татан авч ашиглах зорилт тавин ажиллаж байна.<br>-Тус газрын зүгээс эрүүл мэндийн нэгдсэн</td></tr>
</table>
</td><td>30%</td><td></td><td></td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><td></td><td></td><td></td><td>мэдээллийн санг бий болгох техникийн болон бэлтгэл ажлыг хангасан.</td></tr>
<tr><td>Нийт дүн</td><td>-</td><td>-</td><td></td></tr>
<tr><td>Үр дүн, үр нөлөө</td><td colspan="3">Эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн сан бий болоогүй байгаа тул ямар нэгэн үр дүн, үр нөлөө гараагүй байна.</td></tr>
<tr><td>Тайлбар</td><td colspan="3">Энэхүү арга хэмжээ нь төсөв санхүү болон хэрэгжүүлэгч бусад байгууллагаас шалтгаалан хэрэгжээгүй байна.</td></tr>
</table>
<table>
<tr><td colspan="2">2016 оны</td></tr>
<tr><td>Улсын төсөвт туссан дүн</td><td>Хүлээгдэж буй гүйцэтгэл</td></tr>
<tr><td>-</td><td>-Эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох.</td></tr>
</table>
</td>
<td></td>
<td></td>
<td></td>
</tr>
<tr><td colspan="7">ДӨРӨВ. АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН</td></tr>
<tr>
<td>4</td>
<td>258.Монгол Улсын иргэдийн гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, консулын үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгох ажлыг зохион байгуулах</td>
<td>258.4.Гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгоно.<br><br>Хэрэгжүүлэх байгууллага: ГХЯ, СЯ, ХЗЯ, СЕХ, ҮСГ<br><br>Хугацаа: 2012-2016 он</td>
<td>
<table>
<tr><td rowspan="2">Хугацаа</td><td colspan="2">Төсөв</td><td rowspan="2">Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</td></tr>
<tr><td>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ</td><td>Төсвийн гүйцэтгэл</td></tr>
<tr><td>2012 он</td><td>-</td><td>-</td><td>-Монгол Улсаас гадаад Улсад суугаа Элчин сайдын яам, Консулын газраар дамжуулан гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын 37612 иргэнийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулсан.</td></tr>
<tr><td>2013 он</td><td>-<br>-<br>-</td><td>-<br>-<br>-</td><td>-Монгол Улсаас гадаад Улсад суугаа Элчин сайдын яам, Консулын газраар дамжуулан гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын 1412 иргэнийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулсан.<br>-Гадаад харилцааны яамтай хамтран ажиллах уулзалт зохион байгуулж, бүртгэлийн үйлчилгээг шуурхай, уян хатан хүргэх талаар тус газраас Гадаад улсад байгаа Монгол Улсын Элчин сайдын яамдууд руу удирдамж, заавар, чиглэл, зөвлөгөө хүргүүлсэн.<br>-Гадаадад байгаа иргэдийг шинэчилсэн бүртгэлд хамруулах, гадаадад байгаа иргэдийн бүртгэл хөтлөх оффлайн</td></tr>
</table>
</td>
<td>100%</td>
<td></td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | програм хангамжийг шинэчлэн боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн. | | | | |
| | | | | 35.4 сая төгрөг | 35.4 сая төгрөг | -Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал авах ажиллагааг гадаад улсад байгаа ЭСЯ, ДТГ-уудад зохион байгуулах ажлын хүрээнд програм хангамжийг суурилуулах, сургалт зохион байгуулах, холбогдох тохиргоог хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт 39 ЭСЯ, ДТГ-уудад програм хангамж суулгаж, холбогдох сургалтыг хийсэн. | | | | |
| | | | | 7.3 сая төгрөг | 7.3 сая төгрөг | -Монгол Улсаас БНХАУ-ын Бээжин, Хөх хот, Эрээн хотод суугаа Эё÷èí ñàéäûí ÿàì, Консулын газрын иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд шалгалт хийж, Гадаад харилцааны яаманд арга зүйн зөвлөмж хүргүүлсэн. | | | | |
| | | | 2014 он | - | - | -Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Консулын газраар дамжуулан гадаад Улсад амьдарч байгаа Монгол Улсын 826 иргэнийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулсан. | | | | |
| | | | | 8.3 сая төгрөг | 8.3 сая төгрөг | -БНСУ-ын Сөүл хотод суугаа Дипломат төлөөлөгчийн газарт бүртгэгдэж байгаа иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг шалган зааварчилж, зөвлөмж хүргүүлсэн. | | | | |
| | | | | - | - | -Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт “Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын иргэний улсын бүртгэл хариуцсан ажилтнуудад өгөх зөвлөмж”-ийг хүргүүлсэн. | | | | |
| | | | | - | - | -УБЕГ-ын даргын 2014 оны 1813 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан иргэний үнэмлэх дахин авах хүсэлтийн маягтыг баталсан. | | | | |
| | | | 2015 он | - | - | -Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Консулын газраар дамжуулан гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын 839 иргэнийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулсан. | | | | |
| | | | | - | - | -Консулын үйлчилгээг шуурхай, | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүртээмжтэй болгох ажлыг бүртгэлийн оффлайн програм хангамжийг шинэчлэн БНХАУ-ын Хөх хот, Индонези, Сингапур, АНУ-ын Сан Франциско, Шведын Стокгольм хотод суух консулын газрын бүртгэлийн програм хангамж бүхий зөөврийн компьютерийн мэдээллийн сан болон програмд гарсан алдааг засч хүргүүлсэн. | | | | |
| | | | | 8.6 сая төгрөг | 8.6 сая төгрөг | -Монгол Улсаас АНУ-ын Сан Франциско хотод суугаа Ерөнхий консулын газрын иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг хийж, цаашид анхаарах асуудлын талаар заавар зөвлөмж өгсөн. Шалгалтын явцад Монгол Улсаас АНУ-ын Вашингтон хотод суугаа ЭСЯ-ны иргэний улсын бүртгэл хөтөлж байгаа ажилтануудтай видео хурал хийж, холбогдох асуултанд хариулж, тус ЭСЯ-нд 2015 онд бүртгэгдсэн бүртгэлээс түүвэрчлэн онлайнаар хянаж, илэрсэн зөрчилд тулгуурлан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | | | | |
| | | | | - | - | -Хилийн чанад дахь Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын газарт /АНУ, БНЧУ, БНТУ, БНФУ, ХБНГУ, БНБУ, БНИУ, БНУУ, БНШУ/ иргэний гэр бүлийн байдлын бүртгэл, ИУБ маягт хөтлөлтийн байдалд хяналт шалгалтыг явуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зорилгоор зөвлөмж хүргүүлсэн. | | | | |
| | | | | - | - | -Гадаад улсад суугаа ЭСЯ-нд хийгдсэн үндэсний энгийн гадаад паспортын сунгалтын бүртгэлийг системд оруулснаар гадаад паспорт сунгагдсан эсэх талаарх мэдээлэл цахим санд тусдаг болгож програм хангамжид өөрчлөлт оруулсан. | | | | |
| | | | | - | - | -Төрсний гэрчилгээний хуучин маягт ЭСЯ болон консулын газруудад дуусч байгаатай холбогдуулан гадаадад ашиглаж байгаа офлайн програмыг шинэчлэн шинэ төрсний гэрчилгээн дээр хэвлэдэг болгосон. | | | | |
| | | | | - | - | -Гадаадад байгаа иргэдээс Монгол Улсаас | | | | |

| | | | |
|---|---|---|---|
| | - | - | гадаад улсад суух Элчин сайдын яам, Консулын газраар дамжуулан иргэний үнэмлэхээ дахин авах хүсэлтийг хүлээн авч, иргэний үнэмлэхийг хүргүүлдэг болсон. 2015 онд Чех, Швед, Тайланд улсад ажиллаж байгаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт иргэдийн хүсэлтийн дагуу 22 иргэний иргэний үнэмлэхийг хүргүүлсэн.<br>-Гадаад хэргийн яам болон АНУ, Европ, Ази тивийн бүсэд байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газартай хамтран 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдөр онлайн сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад Иргэний бүртгэл, гадаад паспортын газрын дарга, улсын ахлах бүртгэгч нар оролцож, иргэний улсын бүртгэл хөтлөхөд гарч байгаа алдаа, цаашид анхаарах асуудлын талаар хичээл зааж, консулын ажилтнуудын сонирхсон асуултанд хариулж, заавар, зөвлөмж өгсөн. |
| Нийт дүн | 59.6 сая төгрөг | 59.6 сая төгрөг | |
| Үр дүн, үр нөлөө | Ãàäààäààä áàéãàà Ìîíãîë Óëñûí èðãýäийн Улсын á¿ðòãýëèéí үйлчилгээнд түргэн шуурхай хамрагдах боломж нэмэгдэж, бүртгэлийн үйлчилгээний чанар сайжирсан. | | |
| Тайлбар | - | | |




| 2016 оны | |
|---|---|
| Улсын төсөвт туссан дүн | Хүлээгдэж буй гүйцэтгэл |
| - | Байхгүй |

## ТАВ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | 274.Төр засгийг иргэдэд нээлттэй, тунгалаг болгох цогц арга хэмжээ авах | 274.8.Төрийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хяналт-шинжилгээ үнэлгээний чадавхийг сайжруулна.<br><br>Хэрэгжүүлэх байгууллага: ЗГХЭГ, Яам, Агентлаг, АНЗД<br><br>Хугацаа: 2012-2016 он | | 100% | | |

| Хугацаа | Төсөв | | Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа |
|---|---|---|---|
| | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ | Төсвийн гүйцэтгэл | |
| 2012 он | - | - | |
| 2013 он | - | - | -Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам" батлагдсан бөгөөд уг журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт, төсөл, хөтөлбөрийн биелэлт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| 2014 он | - | - | -Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал” батлагдсан бөгөөд уг аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>-УБЕГ-ын даргын 2014 оны 1477 дугаар тушаалаар “Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ыг батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан.<br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажиллаж буй албан хаагчдыг 4 удаагийн сургалт, семинарт хамруулсан. Үүнд: Хууль зүйн яамнаас зохион байгуулсан “Хяналт-шинжилгээ”, “Эрсдэлийн үнэлгээ”, “Зайны хяналт” сэдэвт сургалт, семинар, Удирдлагын академиас зохион байгуулдаг “Төрийн удирдлагын мэргэшүүлэх сургалт” /Төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлага/. |
| 2015 он | - | - | -УБЕГ-ын даргын 2015 оны 1748 дугаар тушаалаар УБЕГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалд өөрчлөлт оруулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.<br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажиллаж буй албан хаагчдыг 3 удаагийн сургалт, семинарт хамруулсан. Үүнд: Хууль зүйн яамнаас зохион байгуулсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг боловсруулахад анхаарах асуудлын талаарх арга зүйн сургалт”, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийг байгууллагын төлөвлөлттэй уялдуулах нь” сэдэвт сургалт, УБЕГ-аас зохион байгуулсан “Гүйцэтгэлийн үнэлгээ” сэдэвт сургалт. |
| Нийт дүн | - | - | |
| Үр дүн, үр нөлөө | Хяналт-шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчин боловсронгуй болж, албан хаагчдыг холбогдох сургалт, семинарт хамруулснаар õÿíàëò-øèíæèëãýý ¿íýëãýýíèé ÷àäàâõè ñàéæèðсан. | | |
| Тайлбар | | | |

| 2016 оны |
|---|

<table>
<tr>
<td>6</td>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><td>Улсын төсөвт туссан дүн</td><td>Хүлээгдэж буй гүйцэтгэл</td></tr>
<tr><td>-</td><td>-Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.<br>-Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны А/60 дугаар тушаалаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албан хаагчдыг чадавхижуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах.</td></tr>
</table>
</td>
<td></td>
<td></td>
<td></td>
</tr>
<tr>
<td>6</td>
<td>278.Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлснээр иргэн зөвхөн нэг цонхоор, нийтийн нэг албан хаагчтай харьцах зарчмыг тогтоож, бусад шат дамжлагад төрийн байгууллагууд хоорондоо харьцах замаар иргэдэд үйлчлэх</td>
<td>278.1.Төрийн үйлчилгээнд цахим програм хангамж бүхий нээлттэй үйлчилгээг нэвтрүүлж, иргэдээс байгууллага, албан хаагчдад хандаж тавьсан хүсэлт, саналыг хүлээн авсан ажилтан өөрөө хариуцан бусад төрийн байгууллага, ажилтантай цахим шуудангаар хууль тогтоомжийн дагуу харилцаж хариу авч, хүсэлт гаргасан иргэнд үйлчилдэг тогтолцоонд шилжин хэрэгжүүлнэ.<br><br>Хэрэгжүүлэх байгууллага: Яам, Агентлаг, АНЗД, Төсөвт байгууллага<br><br>Хугацаа: 2012-2016 он</td>
<td>
<table>
<tr><td rowspan="2">Хугацаа</td><td colspan="2">Төсөв</td><td rowspan="2">Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</td></tr>
<tr><td>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ</td><td>Төсвийн гүйцэтгэл</td></tr>
<tr><td>2012 он</td><td>-<br><br>577.1 сая төгрөг</td><td>-<br><br>617.6 сая төгрөг</td><td>-Мянганы сорилтын сангийн “Хөрөнгийн эрхийн төсөл”-ийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг, бүсийн тулгуур 8 аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, ePRS систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, архивын баримтын 8.82%-ийг цахимжуулж, бүртгэлийн үйлчилгээнд цахим програм хангамжийг ашигладаг болсон.<br>-БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-тай хамтран иргэний баримтын архив, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтыг цахимжуулах, шинэ програм хангамж нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтын 7.58%-ийг, иргэний баримтын архивын 3.23%-ийг цахимжуулсан.</td></tr>
<tr><td>2013 он</td><td>-</td><td>-</td><td>-Мянганы сорилтын сангийн “Хөрөнгийн эрхийн төсөл”-ийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг, бүсийн тулгуур 8 аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, ePRS систем нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж, архивын баримтын</td></tr>
</table>
</td>
<td>100%</td>
<td></td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 70.22%-ийг цахимжуулсан. | | | | |
| | | | | | 618.7 сая төгрөг | 661.2 сая төгрөг | -БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-тай хамтран иргэний баримтын архив, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтыг цахимжуулах, шинэ програм хангамж нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтын 67.8%-ийг, иргэний баримтын архивын 25.83%-ийг цахимжуулсан. | | | | |
| | | | | | - | - | -Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ авах хүсэлт гаргасан иргэний хаяг болон иргэний бүртгэлтэй холбоотой бусад мэдээллийг иргэний бүртгэлийн онлайн санг ашиглан шалгах боломжтой болсон. | | | | |
| | | | | | - | - | -Засгийн газрын 2013 оны “Нэг цонхны үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 153 дугаар тогтоолоор баталсан “Нэг цонхны үйлчилгээний төвийн үйл ажиллагааны журам”-ыг хэрэгжүүлж, “Нэг цонх”-оор иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, үйлчилгээний шат дамжлагыг багасган, иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос, түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. | | | | |
| | | | | 2014 он | - | - | -Мянганы сорилтын сангийн “Хөрөнгийн эрхийн төсөл”-ийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг, бүсийн тулгуур 8 аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, ePRS систем нэвтрүүлэх ажлыг бүрэн дуусгаж, архивын баримтын 100% цахимжуулсан. | | | | |
| | | | | | 2.7 сая төгрөг | 2.7 сая төгрөг | -Сэлэнгэ аймгийн Мандал бүс /Мандал, Баянгол сум/, Сайхан бүс /Сайхан, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сум/-ийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг аймаг, орон нутгийн удирлагатай хамтран бүрэн цахимжуулсан. | | | | |
| | | | | | 1210.8 сая төгрөг | 1173.5 сая төгрөг | -БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-тай хамтран иргэний баримтын архив, хуулийн | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | этгээдийн бүртгэлийн архивын баримтыг цахимжуулах, шинэ програм хангамж нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтын 100%-ийг, иргэний баримтын архивын 55%-ийг цахимжуулсан. | | | | |
| | | | | | - | - | -Иргэний бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж байгаатай холбогдон цахимжсан хувийн хэргээс “Мэдээлэл удирдах систем”-ийг ашиглан лавлагаа, мэдээлэл олгодог болсон. | | | | |
| | | | | | - | - | -2014 онд Архангай аймгийн Жаргалант, Дорноговь аймгийн Замын-Үүд, Увс аймгийн Тэс, Ховд аймгийн Үенч, Хөвсгөл аймгийн Тариалан, нийслэлийн Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 16 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороонд “Нэг цонхны үйлчилгээ”-ний төв байгуулагдаж, тус газрын улсын бүртгэгч нар иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. | | | | |
| | | | | 2015 он | 721.6 сая төгрөг | 593.9 сая төгрөг | -Иргэний баримтын архивын баримтыг цахимжуулах, шинэ програм хангамж нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж, иргэний баримтын архивын 88.05%-ийг цахимжуулсан. | | | | |
| | | | | | 3.1 сая төгрөг | 3.1 сая төгрөг | -Баянхонгор, Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тухайн аймаг, орон нутгийн дэмжлэгтэйгээр бүрэн дуусгаж, ePRS системийг нэвтрүүлэн бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байна. | | | | |
| | | | | | - | - | -2015 оны байдлаар 14 аймгийн Засаг даргын Тамгын газар, 94 сумын Засаг даргын Тамгын газар, нийслэлийн 5 дүүргийн Засаг даргын Тамгын газарт үйл ажиллагаа явуулж буй “Нэг цонхны үйлчилгээний төв”-д тус газрын иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Үлдсэн 7 аймагт Улсын бүртгэлийн хэлтсийн байрнаас иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг, 4 дүүрэгт дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд байрлах Бүртгэлийн хэлтсийн байрнаас иргэн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг төвлөрсөн байдлаар үзүүлж байна. Мөн нийслэлийн 152 хороонд хорооны ажлын байранд иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. | | | | |
| | | | | - | - | -Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр батлагдаж, 2015 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн этгээдийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх портал сайт болон хуулийн этгээдийн нэрийг онлайнаар шинээр авах, хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах, хуулийн этгээдийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах, үйлчилгээний дараалллыг урьдчилан захиалах хүсэлт хүлээн авах, хуулийн этгээдийн гэрчилгээг онлайнаар харах агуулга бүхий үйлчилгээний вэб портал бий болгож, хэрэглээнд нэвтрүүлсэн. | | | | |
| | | | | - | - | -“Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг нийслэлийн хэмжээнд үйлчилгээний 3 дугаар байрнаас нэг цэгийн үйлчилгээгээр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн. | | | | |
| | | | Нийт дүн | 3134.0 сая төгрөг | 3052.0 сая төгрөг | | | | | |
| | | | Үр дүн, үр нөлөө | Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим програм хангамж нэвтрүүлснээр иргэд улсын бүртгэлийн үйлчилгээг орон зай цаг хугацаанаас үл хамааран цахим хэлбэрээр авах нөхцөл | | | | | | |

| | |
|---|---|
| | бүрдсэн. Цахим хэлбэрээр бүртгэлийн үйлчилгээг авсанаар иргэд зардал мөнгө, цаг хугацаа хэмнэх болсон. |
| Тайлбар | - |

**Улсын бүртгэлийн архивын баримтын цахимжуулалтын хувь**




| 2016 оны | |
|---|---|
| Улсын төсөвт туссан дүн | Хүлээгдэж буй гүйцэтгэл |
| 1416.3 сая төгрөг | Иргэний баримтын архивын баримтыг цахимжуулах ажлыг бүрэн дуусгах. |

7

278.2.Засгийн газар, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр иргэдийн хүсэлт, санал, гомдлыг хүлээн авах “нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлэн хариу өгдөг журамд бүрэн шилжинэ.

Хэрэгжүүлэх байгууллага: ЗГХЭГ, Агентлаг, АНЗД, Төсөвт байгууллага

| Хугацаа | Төсөв | | Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа |
|---|---|---|---|
| | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ | Төсвийн гүйцэтгэл | |
| 2012 он | - | - | -Тус газар нь иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг Засгийн газрын http://zasag.mn/ цахим хуудас дахь http://11-11.mn/ мэдээллийн төв, байгууллагын http://burtgel.gov.mn/ цахим хуудас дахь “Зочны дэвтэр”, “Улсын бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890” |

100%

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>Хугацаа: 2012-2016 он</td>
<td>
<table>
<tr><td></td><td></td><td></td><td>дугаарын утас, “Иргэнд ээлтэй утас: 70122014”, “Онлайн лавлах 1800-1890” мессенжер, Фэйсбүүк, өргөдөл, гомдол хариуцсан ажилтан амаар болон бичгээр, санал, хүсэлтийн хайрцаг, дэвтрээр тус тус хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэж байна.<br>-2012 онд нийт 4195 өргөдөл, гомдол, санал, хүсэлт тус газарт ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан.</td></tr>
<tr><td>2013 он</td><td>-</td><td>-</td><td>-2013 онд нийт 4865 өргөдөл, гомдол, санал, хүсэлт тус газарт ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан.</td></tr>
<tr><td>2014 он</td><td>-</td><td>-</td><td>-2014 онд нийт 13601 өргөдөл, гомдол, санал, хүсэлт тус газарт ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан.</td></tr>
<tr><td>2015 он</td><td>-</td><td>-</td><td>-2015 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 9964 өргөдөл, гомдол, санал, хүсэлт тус газарт ирүүлснээс 8906 буюу 89.4%-ийг шийдвэрлэж, 12 буюу 0.12%-ийг бусад байгууллагад шилжүүлж, 1046 буюу 10.4% нь шийдвэрлэлтийн шатандаа байна.</td></tr>
<tr><td>Нийт дүн</td><td>-</td><td>-</td><td></td></tr>
<tr><td>Үр дүн, үр нөлөө</td><td colspan="3">Иðãýäèéí санал, õ¿ñýëò, өргөдөл, ãîìäëûã Ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд тус бүр нэг цэгээс õ¿ëýýí àâч, хариу өгдөг болсноор санал, õ¿ñýëò, өргөдөл, ãîìäëûн шийдвэрлэлтийн байдал, удирдлагын хяналт сайжирч, иргэдийн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэдэг болсон.</td></tr>
<tr><td>Тайлбар</td><td colspan="3">2014 оноос тус газарт ирүүлэх өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн  тоо эрс нэмэгдсэн нь системийн хэмжээнд өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг гаргадаг болсонтой холбоотой болно.</td></tr>
</table>
</td>
<td></td>
<td></td>
<td></td>
</tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>


<table>
<tr><td colspan="2">2016 оны</td></tr>
<tr><td>Улсын төсөвт туссан дүн</td><td>Хүлээгдэж буй гүйцэтгэл</td></tr>
<tr><td>-</td><td>Байхгүй</td></tr>
</table>
</td>
<td></td>
<td></td>
<td></td>
</tr>
<tr>
<td>8</td>
<td></td>
<td>278.2.Засгийн газар, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр иргэдийн хүсэлт, санал, гомдлыг хүлээн авах “нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлэн хариу өгдөг журамд бүрэн шилжинэ.<br><br>Хэрэгжүүлэх байгууллага: ЗГХЭГ, Агентлаг, АНЗД, Төсөвт байгууллага<br><br>Хугацаа: 2012-2016 он</td>
<td>
<table>
<tr><td rowspan="2">Хугацаа</td><td colspan="2">Төсөв</td><td rowspan="2">Хэрэгжүүлсэн үйл ажиллага</td></tr>
<tr><td>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ</td><td>Төсвийн гүйцэтгэл</td></tr>
<tr><td>2012 он</td><td>-</td><td>-</td><td>-Төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох Datasharing системийг байгуулах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 99 дүгээр тушаалаар баталсан “Мэдээллийн нэгдсэн сүлжээ болон толгой компьютер ашиглах, түүний нууцыг хадгалах, хамгаалах, мэдээлэл солилцох журам”-ын дагуу Тагнуулын ерөнхий газраас олгосон зөвшөөрлийг үндэслэн холбогдох төрийн байгууллагатай гэрээ байгуулан Улсын бүртгэлийн</td></tr>
</table>
</td>
<td>100%</td>
<td></td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийн сангаас сервис бэлтгэн “Үндэсний дата төв” УТҮГ-аар дамжуулан онлайн хэлбэрээр мэдээллээр хангах, солилцох ажлыг хийсэн.<br>-Тухайн байгууллагууд нь Улсын бүртгэлийн байгууллагаас лавлагаа мэдээлэл авахын оронд тус байгууллагын мэдээллийн сангаас холбогдох мэдээллийг харж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>-2012 онд 13 төрийн байгууллага /Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Замын цагдаагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК, Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Гадаадын хөрөнгө оруулалтын газар/-тай гэрээ байгуулан, онлайн хэлбэрээр мэдээлэл солилцон ажилласан байна. | | | | |
| | | | 2013 он | - | - | -2013 онд 2 төрийн байгууллага /Нийгмийн даатгалын ерөнхий газар, Монгол банк/-тай шинээр гэрээ байгуулан, онлайн хэлбэрээр мэдээлэл солилцон ажилласан байна. | | | | |
| | | | 2014 он | - | - | -2014 онд 7 төрийн байгууллага /Үндэсний статистикийн хороо, Боловсрол, шинжлэх ухааны яам, Авилгатай тэмцэх газар, Ашигт малтмалын газар, Худалдан авах ажиллагааны газар, “Үндэсний дата төв” УТҮГ, “Төрийн орон сууны корпораци” ТӨҮГ/-тай шинээр гэрээ байгуулан, онлайн хэлбэрээр мэдээлэл солилцон ажилласан байна. | | | | |
| | | | 2015 он | - | - | -2015 онд 4 төрийн байгууллага /Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Хууль зүйн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Сангийн яам/-тай шинээр гэрээ байгуулан, онлайн хэлбэрээр мэдээлэл солилцон ажилласан байна. | | | | |
| | | | Нийт дүн | - | - | | | | | |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><td>Үр дүн, үр нөлөө</td><td>Төрийн эрх бүхий байгууллагууд Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн санд холбогдож, цахим хэлбэрээр мэдээлэл лавлагаа авдаг болсноор төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо сайжирч, төрийн үйлчилгээ түргэн шуурхай болох боломж бүрдсэн.</td></tr>
<tr><td>Тайлбар</td><td>-</td></tr>
</table>
<table>
<tr><td colspan="2">2016 оны</td></tr>
<tr><td>Улсын төсөвт туссан дүн</td><td>Хүлээгдэж буй гүйцэтгэл</td></tr>
<tr><td>-</td><td>Байхгүй</td></tr>
</table>
</td>
<td></td>
<td></td>
<td></td>
</tr>
<tr>
<td>9</td>
<td></td>
<td>278.5.Цахим гарын үсэг, цахим иргэний үнэмлэхийг ашиглан үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлж шат дамжлагыг цөөлөх, хялбарчлах арга хэмжээ авна.<br><br>Хэрэгжүүлэх байгууллага: ЗГХЭГ, МТШХХГ, Холбогдох яам, агентлаг, ХАБСТ<br><br>Хугацаа: 2012-2016 он</td>
<td>
<table>
<tr><td rowspan="2">Хугацаа</td><td colspan="2">Төсөв</td><td rowspan="2">Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</td></tr>
<tr><td>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ</td><td>Т свийн гүйцэтгэл</td></tr>
<tr><td>2012 он</td><td>-</td><td>-</td><td></td></tr>
<tr><td>2013 он</td><td>-<br><br>-</td><td>-<br><br>26.4 сая төгрөг</td><td>-Засгийн газрын 2012 оны “Төрийн байгууллагын цахим мэдээллийн санг “Үндэсний дата төв” УТҮГ-т шилжүүлэн байршуулах тухай” 146 дугаар тогтоолын дагуу иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сан бүхий сервер компьютерийг “Үндэсний дата төв” УТҮГ-т шилжүүлэн байршуулсан.<br>-“Үндэсний дата төв” УТҮГ-т байршуулсан мэдээллийн сангаар дамжуулан Төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинаар иргэний бүртгэлийн 6 төрлийн лавлагаа, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн түүхчилсэн лавлагаа олгодог болсон. 2013 онд иргэний бүртгэлийн 93499 лавлагаа, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 738 лавлагаа, нийт улсын бүртгэлийн 94237 лавлагааг ТҮЦ машинаар олгосон байна.<br>-ТҮЦ машинаар мөн Татварын ерөнхий газрын 4 төрлийн лавлагаа олгодог болсон.</td></tr>
</table>
</td>
<td>90%</td>
<td></td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2014 он | 78.4 сая төгрөг<br>-<br> | 78.4 сая төгрөг<br>- | -ТҮЦ машинаар олгох лавлагаа, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хуулийн этгээдгүй тухай лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа, иргэний үнэмлэх дахин авах хүсэлтийг ТҮЦ машинаар хүлээн авч шийдвэрлэдэг болсон. 2014 онд ТҮЦ машинаар иргэний бүртгэлийн 603048 лавлагаа, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 46863 лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн 2803 лавлагаа олгож, иргэний үнэмлэх дахин авах 9304 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Нийт ТҮЦ машинаар улсын бүртгэлийн 662018 лавлагаа, үйлчилгээ үзүүлсэн байна.<br>-ТҮЦ машинаас Нийгмийн даатгалын лавлагаа, Гаалийн байгууллагад өртэй эсэх лавлагаа олгож, Цахилгааны төлбөр төлөх үйлчилгээг үзүүлдэг болсон. | | | | |
| | | | | 2015 он | 65.6 сая төгрөг<br>- | 65.6 сая төгрөг<br>- | -2015 онд ТҮЦ машинаар иргэний бүртгэлийн 841875 лавлагаа, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 61022 лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн 6357 лавлагаа олгож, иргэний үнэмлэх дахин авах 24797 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Нийт ТҮЦ машинаар 934051 лавлагаа, үйлчилгээ үзүүлсэн байна.<br>-ТҮЦ машинаар тус газрын “Эд хөрөнгөтэй эсэх хураангуй лавлагаа”, ”Эд хөрөнгөтэй эсэх дэлгэрэнгүй лавлагаа”-г нэмж олгох талаар Хууль зүйн яам, МШХХТГ, “Үндэсний дата төв” УТҮГ-т санал хүргүүлсэн. “Үндэсний дата төв” УТҮГ нь гүйцэтгэгч “Аствишн” ХХК-иас ТҮЦ машины системийн эх кодыг хүлээн авах ажил бүрэн дуусаагүй тул системийн эх кодыг шинэчлэх ажил хүлээгдэж байна. | | | | |
| | | | | Нийт дүн | 144 сая төгрөг | 170.4 сая төгрөг | | | | | |
| | | | | Үр дүн, үр нөлөө | Цахим үнэмлэх, хурууны хээгээ ашиглан ТҮЦ машинаас Улсын бүртгэлийн лавлагаа, үйлчилгээ авч байгаа нь иргэдийн цаг зав, хөрөнгө мөнгийг хэмнэж буй томоохон дэвшилтэт | | | | | | |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><td></td><td>үйлчилгээ болсон бөгөөд иргэд бүртгэлийн үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран цахимаар авах эхлэл болсон.</td></tr>
<tr><td>Тайлбар</td><td>-</td></tr>
</table>


<table>
<tr><td colspan="2">2016 оны</td></tr>
<tr><td>Улсын төсөвт туссан дүн</td><td>Хүлээгдэж буй гүйцэтгэл</td></tr>
<tr><td>120.0 сая төгрөг</td><td>-ТҮЦ машинаас олгож буй лавлагаа, үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх;<br>-“Эд хөрөнгөтэй эсэх хураангуй лавлагаа”, ”Эд хөрөнгөтэй эсэх дэлгэрэнгүй лавлагаа”-г ТҮЦ машинаас олгох.</td></tr>
</table>
</td>
<td></td>
<td></td>
<td></td>
</tr>
<tr>
<td>10</td>
